**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

# Баянхонгор аймгийн Политехникийн коллежийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: БНА-2023/169/НА-СТА-ТШ3**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Баянхонгор хот<br>2023 оны 02 дугээр сарын 05 | Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат<br>Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn<br>Аудитын менежер: А.Цээням<br>Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn<br>Аудитор: Н.Бүнчинсүрэн<br>Утас: 99049866 Цахим хаяг: bunchinsurenn@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**АГУУЛГА**

1. Хараат бус аудиторын дүгнэлт……………………………………………………………………………………
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ……………………………………………………………
3. Санхүүгийн тайлангийн тодруулга……………………………………………………………………………………
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа……………………………………………………………………………
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин……………………………………………………………………………
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ……………………………………………………………………
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт………………………………
4. Аудитын тайлан ……………………………………………………………………………………………………
4.1 Ерөнхий зүйл ………………………………………………………………………………………………………
4.2 Материаллаг байдал …………………………………………………………………………………………………
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт………………………………………………………………………
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ……………………………
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт …………………………………………………
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ………………………………………………………………………
5. Аудитын илрүүлэлт ……………………………………………………………………………………………………
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл ………………………………………………………………

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584
Цахим шуудан:procurement. bayankhongor@audit.gov.mn

2023.02.13 № 2/10

танай ____________ -ны №____________ -т

БАЯНХОНГОР АЙМГИЙН ПОЛИТЕХНИК
ГАЗРЫН ТӨСВИЙН ЗАХИРАГЧ
Д.БАТ-ОРШИХ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Политехник коллежийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Политехник коллежийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй болно.

**Аудитын гол асуудал**

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 2,769,100.1 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 287,199.1 мянган төгрөгөөр буюу 11.5 хувиар өссөн байна.

**Бусад асуудлын хэсэг**

Баянхонгор аймгийн Политехник коллеж нь 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилго, 7 зорилтын хүрээнд зорилтын хүрээнд 52 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 94.0 хувиар үнэлсэн байна.

005020128

D/2023-A4 Alban toot.doc

Баянхонгор аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2022 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй, аудитад ажил гүйлгээг түүврийн аргыг ашиглан гүйцэтгэсэн болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ

D/2023-A4 Alban toot.doc

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **354,855,023.11** | **287,764,205.11** |
| **33** | **АВЛАГА** | 4,592.00 | 4,592.00 |
| **335** | **Бусад авлага** | 4,592.00 | 4,592.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 4,592.00 | 4,592.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 354,850,431.11 | 287,759,613.11 |
| **351** | **Түүхий эд материал** | 246,497,522.61 | 222,401,944.61 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 246,497,522.61 | 222,401,944.61 |
| **354** | **Хангамжийн материал** | 108,352,908.50 | 65,357,668.50 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 9,945,080.00 | 7,108,380.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 61,980,788.50 | 36,266,268.50 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 2,308,000.00 | 2,014,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | - | 10,120.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 19,294,900.00 | 8,226,050.00 |
| 35460 | Хүнсний материал | 5,235,340.00 | 1,087,950.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 9,588,800.00 | 10,644,900.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **2,996,010,031.89** | **2,760,051,522.48** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 2,996,010,031.89 | 2,760,051,522.48 |
| **392** | **Биет хөрөнгө** | 2,214,910,031.89 | 1,978,951,522.48 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 2,068,208,664.61 | 2,072,620,064.61 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (436,157,448.05) | (594,045,367.30) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 167,364,900.00 | 167,364,900.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (132,648,675.00) | (146,535,165.00) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 1,772,791,190.42 | 1,798,424,927.42 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (1,333,933,076.90) | (1,444,635,302.36) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 194,609,497.39 | 196,296,605.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (166,884,715.41) | (159,772,309.72) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 19,378,953.00 | 27,217,953.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (18,828,954.07) | (18,994,479.07) |
| 39217 | Ном | 81,009,695.90 | 81,009,695.90 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 781,100,000.00 | 781,100,000.00 |
| 39301 | Програм хангамж | 1,760,735.00 | 1,760,735.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (1,760,735.00) | (1,760,735.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 781,100,000.00 | 781,100,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **3,350,865,055.00** | **3,047,815,727.59** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **3,350,865,055.00** | **3,047,815,727.59** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 3,350,865,055.00 | 3,047,815,727.59 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 1,945,234,164.54 | 1,945,234,164.54 |
| 51101 | Өмч: - төрийн | 1,945,234,164.54 | 1,945,234,164.54 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | (65,548,821.73) | (368,598,149.14) |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (404,571,397.22) | (65,548,821.73) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 339,022,575.49 | (303,049,327.41) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,471,179,712.19 | 1,471,179,712.19 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **3,350,865,055.00** | **3,047,815,727.59** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **2,833,458,659.40** | **2,466,050,750.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **726,304,959.40** | **63,333,200.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 726,304,959.40 | 63,333,200.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 726,304,959.40 | 63,333,200.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 8,542,935.00 | 4,675,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,480,000.00 | - |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 716,282,024.40 | 58,658,200.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,107,153,700.00** | **2,402,717,550.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 2,079,119,700.00 | 1,905,792,300.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 2,079,119,700.00 | 1,905,792,300.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 28,034,000.00 | 31,555,750.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 28,034,000.00 | 31,555,750.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | - | 465,369,500.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | - | 465,369,500.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **2,481,900,943.09** | **2,769,100,077.41** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,481,900,943.09** | **2,769,100,077.41** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 2,279,793,710.95 | 2,553,761,967.74 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,216,817,868.00 | 1,425,901,242.37 |
| 210101 | Үндсэн цалин | 1,216,817,868.00 | 1,399,794,311.37 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | - | 26,106,931.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 158,606,157.35 | 178,866,609.13 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 158,606,157.35 | 155,504,666.86 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | - | 5,713,949.78 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | - | 4,628,239.61 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | - | 1,192,527.42 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | - | 11,827,225.46 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 429,563,432.00 | 400,341,237.43 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 9,162,740.00 | 16,462,885.43 |
| 210302 | Түлш, халаалт | 400,952,000.00 | 361,448,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 19,448,692.00 | 22,430,352.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 28,421,976.51 | 58,963,918.90 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,739,100.00 | 5,215,790.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 5,313,431.00 | 4,083,427.50 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,514,445.51 | 5,168,531.40 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 960,000.00 | 1,795,650.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 13,895,000.00 | 42,700,520.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 24,884,400.00 | 50,298,288.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,138,900.00 | 350,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 15,594,000.00 | 42,827,388.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 8,151,500.00 | 7,120,900.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 13,586,800.00 | 28,234,700.00 |
| 210604 | Урсгал засвар | 13,586,800.00 | 28,234,700.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | - | 429,200.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | - | 429,200.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 14,492,755.00 | 15,549,740.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,102,755.00 | 2,856,636.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,500,000.00 | 2,803,104.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 9,890,000.00 | 9,890,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 393,420,322.09 | 395,177,031.91 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 2,321,800.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 79,927,786.00 | 90,743,522.50 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 313,492,536.09 | 302,111,709.41 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 202,107,232.14 | 215,338,109.67 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 149,535,800.00 | 200,725,800.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 68,210,600.00 | 64,281,200.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 81,325,200.00 | 135,047,100.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 1,397,500.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 52,571,432.14 | 14,612,309.67 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 52,571,432.14 | 14,612,309.67 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | 351,557,716.31 | (303,049,327.41) |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 12,535,140.82 | 0.00 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 12,535,140.82 | 0.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | (12,535,140.82) | (0.00) |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | 339,022,575.49 | (303,049,327.41) |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **2,119,551,635.00** | **2,407,392,550.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **12,397,935.00** | **4,675,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 12,397,935.00 | 4,675,000.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 12,397,935.00 | 4,675,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 10,917,935.00 | 4,675,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,480,000.00 | - |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,107,153,700.00** | **2,402,717,550.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 2,079,119,700.00 | 1,905,792,300.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 2,079,119,700.00 | 1,905,792,300.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 28,034,000.00 | 31,555,750.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 28,034,000.00 | 31,555,750.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | - | 465,369,500.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | - | 465,369,500.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **2,108,104,735.00** | **2,396,522,550.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,108,104,735.00** | **2,396,522,550.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,904,423,102.86** | **2,181,184,440.33** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,216,817,868.00 | 1,421,857,242.37 |
| 210101 | Үндсэн цалин | 770,755,059.00 | 896,863,614.95 |
| 210102 | Нэмэгдэл | 302,558,317.10 | 321,344,812.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 51,034,401.90 | 51,169,999.78 |
| 210104 | Урамшуулал | 92,470,090.00 | 100,426,158.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210105 | Гэрээт ажлын хөлс | - | 52,052,657.64 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 158,606,157.35 | 178,866,609.13 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 111,080,280.21 | 126,900,691.91 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 12,260,339.57 | 13,016,826.57 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 9,744,431.99 | 10,413,421.25 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,317,325.34 | 2,594,188.16 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 23,203,780.24 | 25,941,481.24 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 385,541,732.00 | 400,341,237.43 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 9,162,740.00 | 16,462,885.43 |
| 210302 | Түлш, халаалт | 356,930,300.00 | 361,448,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 19,448,692.00 | 22,430,352.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 25,600,645.51 | 24,937,271.40 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,654,000.00 | 2,463,090.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,920,300.00 | 2,714,200.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,514,445.51 | 5,520,531.40 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,700,000.00 | 2,579,650.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 12,811,900.00 | 11,659,800.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 22,296,620.00 | 48,960,998.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 320,000.00 | 350,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 14,840,620.00 | 41,800,998.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 7,136,000.00 | 6,810,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 9,428,900.00 | 22,983,150.00 |
| 210604 | Урсгал засвар | 9,428,900.00 | 22,983,150.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 512,000.00 | 429,200.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 512,000.00 | 429,200.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 14,492,755.00 | 15,549,740.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,102,755.00 | 2,856,636.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,500,000.00 | 2,803,104.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 9,890,000.00 | 9,890,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 71,126,425.00 | 67,258,992.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 71,126,425.00 | 67,258,992.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **203,681,632.14** | **215,338,109.67** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 151,110,200.00 | 200,725,800.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 68,210,600.00 | 64,281,200.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 81,325,200.00 | 135,047,100.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,574,400.00 | 1,397,500.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 52,571,432.14 | 14,612,309.67 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 52,571,432.14 | 14,612,309.67 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **11,446,900.00** | **10,870,000.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **11,446,900.00** | **10,870,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **1,446,900.00** | **10,870,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 11,446,900.00 | 10,870,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 11,446,900.00 | 10,870,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 6 | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(11,446,900.00)** | **(10,870,000.00)** |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 1,945,234,164.54 | 1,471,179,712.19 | -65,548,821.73 | 3,350,865,055.00 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | 0.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,945,234,164.54** | **1,471,179,712.19** | **-65,548,821.73** | **3,350,865,055.00** |
| C08 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,945,234,164.54** | **1,471,179,712.19** | **-65,548,821.73** | **3,350,865,055.00** |
| D01 | **2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **1,945,234,164.54** | **1,471,179,712.19** | **-65,548,821.73** | **3,350,865,055.00** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,945,234,164.54** | **1,471,179,712.19** | **-65,548,821.73** | **3,350,865,055.00** |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | -303,049,327.41 | -303,049,327.41 |
| D09 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,945,234,164.54** | **1,471,179,712.19** | **-368,598,149.14** | **3,047,815,727.59** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 2,371,161,800.00 | 2,356,654,490.33 | 14,507,309.67 | 99.39 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 2,371,161,800.00 | 2,356,654,490.33 | 14,507,309.67 | 99.39 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 2,170,416,400.00 | 2,155,928,690.33 | 14,487,709.67 | 99.33 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,432,261,900.00 | 1,421,857,242.37 | 10,404,657.63 | 99.27 |
| 210101 | Үндсэн цалин | 928,368,900.00 | 896,863,614.95 | 31,505,285.05 | 96.61 |
| 210102 | Нэмэгдэл | 316,216,700.00 | 321,344,812.00 | (5,128,112.00) | 101.62 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 51,084,000.00 | 51,169,999.78 | (85,999.78) | 100.17 |
| 210104 | Урамшуулал | 84,539,600.00 | 100,426,158.00 | (15,886,558.00) | 118.79 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 52,052,700.00 | 52,052,657.64 | 42.36 | 100.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 178,931,500.00 | 178,866,609.13 | 64,890.87 | 99.96 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 126,965,400.00 | 126,900,691.91 | 64,708.09 | 99.95 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 13,016,900.00 | 13,016,826.57 | 73.43 | 100.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 10,413,500.00 | 10,413,421.25 | 78.75 | 100.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,594,200.00 | 2,594,188.16 | 11.84 | 100.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 25,941,500.00 | 25,941,481.24 | 18.76 | 100.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 400,621,400.00 | 400,341,237.43 | 280,162.57 | 99.93 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 16,472,500.00 | 16,462,885.43 | 9,614.57 | 99.94 |
| 210302 | Түлш, халаалт | 361,448,500.00 | 361,448,000.00 | 500.00 | 100.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 22,700,400.00 | 22,430,352.00 | 270,048.00 | 98.81 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 25,134,100.00 | 24,937,271.40 | 196,828.60 | 99.22 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,468,100.00 | 2,463,090.00 | 5,010.00 | 99.80 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,714,200.00 | 2,714,200.00 | - | 100.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 5,712,000.00 | 5,520,531.40 | 191,468.60 | 96.65 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,580,000.00 | 2,579,650.00 | 350.00 | 99.99 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 11,659,800.00 | 11,659,800.00 | - | 100.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2105** | **Нормативт зардал** | 52,067,300.00 | 48,960,998.00 | 3,106,302.00 | 94.03 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 350,400.00 | 350,000.00 | 400.00 | 99.89 |
| 210502 | Хоол, хүнс | 44,894,500.00 | 41,800,998.00 | 3,093,502.00 | 93.11 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 6,822,400.00 | 6,810,000.00 | 12,400.00 | 99.82 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 14,776,100.00 | 14,657,400.00 | 118,700.00 | 99.20 |
| 210604 | Урсгал засвар | 14,776,100.00 | 14,657,400.00 | 118,700.00 | 99.20 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 460,900.00 | 429,200.00 | 31,700.00 | 93.12 |
| 210702 | Дотоод албан томилолт | 460,900.00 | 429,200.00 | 31,700.00 | 93.12 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 15,834,200.00 | 15,549,740.00 | 284,460.00 | 98.20 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,944,200.00 | 2,856,636.00 | 87,564.00 | 97.03 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 3,000,000.00 | 2,803,104.00 | 196,896.00 | 93.44 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 9,890,000.00 | 9,890,000.00 | - | 100.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 50,329,000.00 | 50,328,992.00 | 8.00 | 100.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 50,329,000.00 | 50,328,992.00 | 8.00 | 100.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 200,745,400.00 | 200,725,800.00 | 19,600.00 | 99.99 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 200,745,400.00 | 200,725,800.00 | 19,600.00 | 99.99 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 64,281,300.00 | 64,281,200.00 | 100.00 | 100.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 135,047,100.00 | 135,047,100.00 | - | 100.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,417,000.00 | 1,397,500.00 | 19,500.00 | 98.62 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 2,371,161,800.00 | 2,356,654,490.33 | 14,507,309.67 | 99.39 |
| 1310 | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,905,792,300.00 | 1,891,565,402.08 | 14,226,897.92 | 99.25 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 1,905,792,300.00 | 1,891,565,402.08 | 14,226,897.92 | 99.25 |
| 1320 | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 465,369,500.00 | 465,089,088.25 | 280,411.75 | 99.94 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 465,369,500.00 | 465,089,088.25 | 280,411.75 | 99.94 |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1.00 | 1.00 | 0.00 | 100.0 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 | 0.00 | 100.0 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | **96** | **101** | -5.00 | 105.2 |
| 620001 | Удирдах ажилтан | 4 | 4 | 0.00 | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 74 | 74 | 0.00 | 100.0 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 18 | 23 | -5.00 | 127.8 |

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан** / төгрөгөөр /

| **Дансны код** | **Үзүүлэлт** | **Өмнөх он** | **Гүйцэтгэл** |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **28,034,000.00** | **36,125,750.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **28,034,000.00** | **36,125,750.00** |
| **210** | **БАРАА, ЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 28,034,000.00 | 36,125,750.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | - | 8,325,750.00 |
| 210604 | Урсгал засвар | - | 8,325,750.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 28,034,000.00 | 27,800,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 28,034,000.00 | 27,800,000.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 28,034,000.00 | 36,115,750.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 28,034,000.00 | 36,115,750.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 28,034,000.00 | 36,115,750.00 |

**3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Политехникийн коллеж нь Мэргэжлийн боловсролын сургалтын үйл ажиллагааг суралцагчийн эрхийг дээдлэн, суралцах, дадлагажих нөхцөлөөр хангаж, сургалтын чанар, хүртээмж, үр дүнг дээшлүүлэх зорилгын хүрээнд

1. Багш, ажиллагсдын мэргэжил, ур чадварын тасралтгүй хөгжлийг хангах
2. Мэргэжлийн хөтөлбөр, төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, цахим е-технологийн арга зүйг нэвтрүүлэн сургалтын чанар, үр дүнг дээшлүүлэх
3. Суралцагчийн олон нийтийн ажилд сайн дураар оролцох, зохион байгуулах дадал хэвшлийг төлөвшүүлэхэд асран хамгаалагчдын үүрэг оролцоог нэмэгдүүлэх
4. Багш, ажиллагсад, суралцагчдын судалгаа, шинжилгээ, инновацын ажлыг дэмжин урамшуулах
5. Төсөл хөтөлбөр, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх
6. “Чанартай сургалт-Бүтээлч түншлэл” зорилгыг хэрэгжүүлэн төгсөгчдийг хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх
7. Бүс, орон нутгийн тэргүүлэх чиглэлтэй уялдуулан эрэлтэд нийцсэн мэргэжилтэй ажилтан бэлтгэх
8. Гүйцэтгэлд суурилсан төлөвлөлт, санхүүжилтийн тогтолцоог эхлүүлэх зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

БШУЯ-ны Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг ба Баянхонгор аймгийн Политехникийн коллежийн 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл

үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Политехникийн коллежийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл суурьиар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Баянхонгор аймгийн Политехникийн коллежийн 2018 оны 4 сарын 04 өдрийн 27 дугаар тушаалаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн баримт бичиг нь мөрдөж байгаа холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

**3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Баянхонгор аймгийн Политехникийн коллежийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Баянхонгор аймгийн Политехникийн коллежийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 3,047,815.7 мянган төгрөг байгаа бөгөөд өмнөх оноос 303,049.3 мянган төгрөгөөр буюу 9.0 хувиар буурсан байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | 4.6 | 4.6 | - |
| Бараа материал | 354,850.4 | 287,759.6 | 67,090.8 |
| Үндсэн хөрөнгө | 5,086,223.64 | 5,125,794.88 | 39,571.24 |
| Хуримтлагдсан элэгдэл | (2,090,213.60) | (2,365,743.36) | (275,529.75) |
| **Нийт хөрөнгө** | **3,350,865.1** | **3,047,815.7** | **303,049.3** |
| Өр төлбөр | - | - | - |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 3,350,865.1 | 3,047,815.7 | 303,049.3 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **3,350,865.1** | **3,047,815.7** | **303,049.3** |

Эх сурвалж: Байгууллагын 2022 оны санхүүгийн тайлан

Авлага дансны үлдэгдэл тайлант оны эхэнд 4.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба өөрчлөлт ороогүй, өр төлбөр байхгүй.

Бараа материалын дансны үлдэгдэл 287,759.6 мянган төгрөг болж өмнөх оноос 67,090.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 149,445.9 мянга, үнэ төлбөргүй хүлээн авсан 3,375.0 мянга бүгд 152,820.9 мянган төгрөгийн орлого авч 219,911.7 мянган төгрөгийн төгрөгийн бараа материалыг зарцуулсантай холбоотой бөгөөд үүнээс тусгай зориулалтын материал 24,095.6 мянга, аж ахуйн материал 25,714.5 мянга, барилгын засварын материал 11,068.9 мянган төгрөгөөр буурсан нь голлох нөлөө үзүүлсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,760,051.4 мянган төгрөг болж 235,958.5 мянган төгрөгөөр буурсан нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 12 сарын 23-ны өдрийн 2/2554 дугаар тогтоолоор 26,581.9 мянган төгрөгийн хөрөнгө данснаас хассан, тайлант онд 302,111.7 мянган төгрөгийн элэгдлийн зардал гарсантай холбоотой байна. Мөн тайлант онд төсвийн хөрөнгөөр 10,870.0 мянга, багш ажиллагсдын хандиваар 1,500.0 мянга, БШУЯ-аас 29,492.8 мянга, хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангаас 9,970.4 мянга, бусад эх үүсвэрээс 14,320.0 мянган төгрөгийн хөрөнгийг орлого авсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,047,815.7 мянган төгрөг болж 303,049.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн 303,049.3 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,536,868.5 мянга, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 16,700.0 мянга нийт зарлагыг 2,553,568.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 64,662.8 мянган төгрөгөөр бууруулж 2,488,905.7 мянган төгрөгөөр анх батлагдсан ба тодотголоор 2,371,161.8 мянган төгрөг болгож 117,743.9 мянган төгрөгөөр бууруулан баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 71804 хөтөлбөрийн 80101, 80112, 80802, 81806 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,371,161.8 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 1,905,792.3 мянган төгрөгийг улсын төсвөөс, 583,113.4 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,905,792.3 мянга, орон нутгийн төсвөөс 465,369.5 мянган төгрөгийн санхүүжилт олгож, зарцуулагдаагүй улсын төсвийн санхүүжилтээс 14,226.9 мянга, орон нутгийн төсвийн санхүүжилтээс 280.4 мянган төгрөгийг тус тус буцаан улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,356,654.5 мянган төгрөг буюу 99.4 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 14,507.4 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| **1** | **71804 Мэргэжлийн боловсрол** | **2,371,161.8** | **2,356,654.5** | **14,507.3** | **99.3** |
| 2 | 80101 үндсэн үйл ажиллагааны зардал | 1,660,152.4 | 1,649,038.6 | 11,113.8 | 99.3 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 3 | 80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал | 200,745.4 | 200,725.8 | 19.6 | 100 |
| 4 | 81806 Дотуур байрны үйлчилгээ | 44,894.5 | 41,801.0 | 3,093.5 | 93.1 |
| 5 | 80112 Нийтлэг үйлчилгээ | 465,369.5 | 465,089.1 | 280.4 | 100 |
| | **Нийт дүн** | **2,371,161.8** | **2,356,654.5** | **14,507.3** | **99.3** |

Эх сурвалж: Төсвийн гүйцэтгэлийн тайлангаас

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд байгууллагын нэмэлт санхүүжилтийн 100030035403 тоот дансанд 36,230.8 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж 105.0 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна

*Хүснэгт 3. Нэмэлт санхүүжилтийн орлого* */мян.төг/*

| д/д | Орлогын төрөл | Авсан санхүүжилт |
|---|---|---|
| 1 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан (Хөдөлмөр эрхлэлтийн түр сургалтын зардал) | 27,8000.0 |
| 2 | Дадлагын орлого | 8,430.8 |
| | Нийт орлогын дүн | 36,230.8 |
| | Улсын төсөвт төвлөрүүлсэн | 105.0 |
| | Нийт зарлагын дүн | 36,125.8 |

Эх сурвалж: Нэмэлт санхүүжилтийн дансны хуулга

Тайлант онд тухайн байгууллагад үндсэн үйл ажиллагааны орлого батлагдаагүй бөгөөд үндсэн үйл ажиллагаанаас орсон орлогыг нэмэлт санхүүжилтийн данс руу төвлөрүүлж зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Политехникийн коллежийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн

үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Бүнчинсүрэн гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Политехник коллежийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 12 дүгээр сарын 30-ны өдрийн 202 дугаар албан бичгээр ирүүлсэн.

2022 оны төсвийн хөрөнгийг захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг Баянхонгор аймгийн Политехникийн коллежийн захирал Д.Бат-Орших, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Ц.Цэвээнсүрэн нар зурж хөрөнгийг захиран зарцуулжээ.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төсвийн гүйцэтгэлийн нийт зардлыг сонгож, материаллаг байдлын түвшин 1.5 хувиар тооцож материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны батлагдсан төсвийн 2,371,161.8 мянган төгрөгөөс тооцоход 35,567.4 мянган төгрөг байгаа ба гүйцэтгэлийн материаллаг байдлыг 70 хувиар буюу 24,897.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тухайн байгууллага нь Төрийн хэмнэлтийн хуулийг баримтлан ажилласан байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь шилэн дансанд мэдээлбэл зохих 2,993,313.4 мянган төгрөгийн 151 мэдээллээс 119 мэдээлэл хугацаандаа оруулж 30 мэдээлэл хугацаа хоцроосон, 1 мэдээллийг мэдээлээгүй байна. Мөн цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 2 мөнгөн гүйлгээний 134,303.8 мянга, зарлагын 1 мөнгөн гүйлгээний 8,559.8 мянган хугацаа хоцроосон, орлогын 7 мөнгөн гүйлгээний 366,652.9 мянга, зарлагын 5 гүйлгээний 83,351.6 мянган төгрөгийн гүйлгээг, тендерийн худалдан авах ажиллагааны 45,000.0 мянган төгрөгийн мэдээллийг мэдээлээгүй байна.

| д/д | Хугацаа | Төрөл | Мэдээлвэл зохих/удаа | Хугацаанд оруулсан | Хугацаа хоцроосон | Мэдээлээгүй | Хугацаа болоогүй |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Бүтэн жил | 11 | 11 | 5 | 4 | 1 | 2 |
| 2 | Хагас жил | 4 | 4 | 4 | 0 | | |
| 3 | Улирал бүр | 1 | 4 | 4 | 0 | | |
| 4 | Сар бүр | 3 | 36 | 28 | 8 | | |
| 5 | Тухай бүр | 8 | 96 | 78 | 18 | | |
| | Нийт | 27 | 151 | 119 | 30 | 1 | 2 |

*Шийдвэрлэсэн нь*: Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т заасан мэдээлэл, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлага, тендерийн худалдан ажиллагааны мэдээллийг бүрэн, үнэн зөв мэдээлж байх зөвлөмжийг хүргүүлэв.

**4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

## 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгээгүй.

### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 95,536.2 мянган төгрөгийн 3 алдаа, зөрчил илэрснээс 87,832.4 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, тэтгэвэрт гарсан албан хаагч ажиллуулж байгаад 1 зөвлөмж өгсөн ба Баянхонгор аймгийн Политехникийн коллежийн захирлын 2022.05.30-ны өдрийн 71 дүгээр албан бичгээр хэрэгжилтийг тооцсон байна.

*Хүснэгт 5. Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | | | | | |
| Албан шаардлага | 2 | 87,832.4 | 2 | 87,832.4 | 100 |
| Зөвлөмж | 1 | 7,703.8 | 1 | 7,703.8 | 100 |
| **Нийт дүн** | **3** | **95,536.2** | **3** | **95,536.2** | **100** |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус сургуулийн дотуур байр МХГ-аас ажиллуулах боломжгүй гэсэн дүгнэлт гарснаас 2022 оны 9 сараас эхлэн хүүхэд хүлээн аваагүй ба аймгаас Эрдэнэмандал ахлах сургуулийн дотуур байранд 6 өрөө гарган 56 хүүхэд амьдарч байна. Тус сургуульд үйл ажиллагааны тогтмол зардлыг төлөөгүй. Хуучин дотуур байрны халаалтыг хичээлийн байртай холбоотой тул салгаагүй зардлыг төлсөөр байгаа нь төсвийн хөрөнгийн үр ашиг гарахгүй байна. 2023 оны 1-р сараас эхлэн ЕБС-д хэрэглэсэн тогтмол зардлыг төлж, байрны асуудлыг шийдвэрлүүлэх нь чухал байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 24,090.8 мянган төгрөгийн алдаа[1] илэрснээс аудитын явцад 24,090.0 мянган төгрөгийн алдааг залруулж алдааг давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

1."Маралгүн" ХХК-ийн халаалтын зардалд 2022.11.30-д 22,590.5 мянган төгрөг шилжүүлсэн бөгөөд нягтлан бодогч гэрээт ажлын хөлсний зардлаар тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 зүйлийн 5.1.4 "Үнэн зөв байх", Сангийн сайдын 190 дүгээр тушаалаар батлагдсан зардлын эдийн засгийн ангилал ашиглах зааврын Гэрээт ажлын ажлын хөлс (210105) ангилалд хамаарахгүй тул санхүүгийн тайланд залруулав.

2. Захирлын 2022.12.22-ны өдрийн А/73 дугаар тушаалаар багш ажилчдын хандиваар хийгдсэн "Шагайн зурхай"-г 1500.0 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгөнд бүртгэх шийдвэр гаргасан байхад хөрөнгөд орлого аваагүй байна. Энэ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4. “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна.” гэсэн заалтыг зөрчиж байгаа тул санхүүгийн тайланд залруулав.

Аудитаар нийт 787.4 мянган төгрөгийн зөрчил[2] илэрснээс, 286.6 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 500.8 төгрөгийн албан шаардлага хүргүүллээ.

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үгнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

### 5.1 Төлбөрийн акт

1. Архивч Ц.Цэрэнмаад 2022 оны 1 сард ажил хавсарсан нэмэгдэл 286.6 мянган төгрөгийг өгөхөөр байхад 573.2 мянган төгрөгийг олгосон байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1 "Ажил олгогч нь ажилтантай тохиролцсоноор ажил хослон гүйцэтгүүлэх, эзгүй байгаа ажилтны үүргийг түр орлон гүйцэтгүүлэх, ажилтны ажлын цагт багтаан өөр ажил албан тушаал хавсран гүйцэтгүүлэх, ажлын ачааллыг нэмэгдүүлэх хэлбэрээр ажиллаж болно" гэсний дагуу Баянхонгор аймгийн Политехникийн захирлын 2022.01.04-ны өдрийн 01 дүгээр тушаалд "40 хувийн нэмэгдэл олгоно" гэсэн заалтыг зөрчсөн байна

**Шийдвэрлэсэн нь**: Ажил хавсарсан нэмэгдэлд илүү олгосон 286.6 мянган төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлж төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

### 5.2 Албан шаардлага

Бичиг хэргийн ажилтан М.Пүрэвсүрэнд 2022 оны 11 сарын цалинд 500.8 мянган төгрөг олгосон атлаа НДШ мэдээлээгүй байна.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 зүйлийн 17.1 дэх хэсэгт “1.Ажил олгогч болон энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагч нь шимтгэл төлөх талаар дор дурдсан үүрэг хүлээнэ” 17.1.1 дэх “Хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь**: Бичиг хэргийн ажилтан М.Пүрэвсүрэнд 2022 оны 11 сарын цалин 500.8 мянган төгрөгийг нөхөн мэдээлэх албан шаардлага хүргүүлэв.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Цалингийн зардалтай холбоотой

*Илрүүлэлт:* Тухайн байгууллага нь ажиллагсдын гарт олгох цалинг олгохдоо НДШ, ХАОАТ-ын суутгалаас гадна хамтын сан, хоолны мөнгө болон бусад суутгалд 53,182.9 мянган төгрөгийг суутгасан байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 119 дүгээр зүйлийн "119.1."Ажил олгогч ажилтны цалин хөлсийг бүрэн хэмжээгээр нь олгох бөгөөд дараах тохиолдолд суутгал хийж болно", 19.1.1.ажилтны нэг сарын дундаж цалин хөлснөөс хэтрэхгүй хэмжээний хохирлыг ажилтнаар нөхөн төлүүлэх тухай ажил олгогчийн шийдвэр гарсан; 119.1.2.шүүхийн, эсхүл хөдөлмөрийн эрхийн маргаан шийдвэрлэх байгууллагын шийдвэр хүчин төгөлдөр болсон; 119.1.3.ажилтанд энэ хуулийн 123.2.3-т заасан хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулсан; 119.1.4.хууль тогтоомжид заасан бусад тохиолдол"-д суутгал хийж болно гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь**: Ажилтан, албан хаагчдын цалингийн зардлаас хуулийн дагуу суутгах суутгалаас бусад суутгалыг суутгахгүй зөвлөмжийг хүргүүлж байна.

2. Дотуур байрны хүүхдийн байр болон ашиглалтын зардалтай холбоотой.

*Илрүүлэлт:* Эрдэнэмандал ахлах сургуулийн дотуур байранд 6 өрөө гарган 56 хүүхэд амьдарч байна. Тус сургуульд үйл ажиллагааны тогтмол зардлыг төлөөгүй. Хуучин дотуур байрны халаалтыг хичээлийн байртай холбоотой тул салгаагүй зардлыг төлсөөр байгаа нь төсвийн хөрөнгийн үр ашиг гарахгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5 “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь**: Дотуур байрны халаалтын зардлыг шийдвэрлэж төсөвт үр ашиггүй зардал гаргахгүй байх зөвлөмжийг хүргүүлж байна.

Дээрх актын биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Халаалтын зардлыг гэрээт ажилтны цалингаар тайлагнасан байна. | 1 | 22,590.5 | | | | | 1 | 22,590.5 | | | | |
| Багш ажилчдын хандиваар хийсэн 1,500.0 мянган төгрөгийн шагайн зурхайг орлого аваагүй байна | 1 | 1,500.0 | | | | | 1 | 1,500.0 | | | | |
| Дүн | 2 | 24,090.5 | | | | | 2 | 24,090.5 | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Архивч Ц.Цэрэнмаад 286.4 мянган төгрөгийн цалин илүү олгосон байна | 1 | 286.4 | 1 | 286.4 | | | | | | | | |
| Бичиг хэргийн ажилтан М.Пүрэвсүрэнгийн 2022 оны 11 сарын НДШ мэдээлээгүй байна. | 1 | 500.8 | | | 1 | 500.8 | | | | | | |
| Ажилтан, албан хаагчдын цалингийн зардлаас хамтын сан, хоолны мөнгө гэх мэт суутгалууд авч байна | 1 | 0 | | | | | 1 | 0 | | | | |
| Дүн | 3 | 787.2 | 1 | 286.4 | 1 | 500.8 | 1 | 0 | 0 | 0 | 0 | 0 |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал** /мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Шилэн дансанд мэдээллийг бүрэн оруулахгүй байна. | 1 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 1 | 0 |
| Дүн | 1 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 1 | 0 |
| Төрийн хэмнэлтийн хуультай холбоотой | | | | | | | | |
| Дотуур байрны барилга мэргэжлийн хяналтын дүгнэлт гарсан ашиглахгүй байгаа мөртлөө ашиглалтын зардал төлж байна. | 1 | 76,338.0 | | | | | 1 | 76,338.0 |
| Дүн | | | | | | | | |
| Нийт дүн | 1 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 1 | 0 |

ooOoo